



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/06

Онги

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалт, 38 дугаар зүйл, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан-овоо сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрийн (Хонгор) гэх газарт байршилтай 5000 м.кв (0.5 га) өвөлжөөний зориулалттай газрын эзэмшигч Сосорбурам овогтой Өлзийсайхан (ЗЛ61080111) нь 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдөр нас барсан. Иймд эхнэр Ням овогтой Улаанхүүхэн (ЗЛ63020501)-д зориулалтаар шилжүүлж 33 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигчийн газрын гэрчилгээг шинэчлэн олгож, газар эзэмших гэрээ байгуулж ажиллахыг аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн (Т.Саранзул)-д зөвшөөрсүгэй.

3. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө цаг тухайд нь төлж байхыг газар эзэмшигч (Н.Улаанхүүхэн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2006 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 22 дугаар захирамжийн хавсралтын 91 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  АМАРСАНАА